2107	Томилолт, зочны зардал	900,000.00	00.00
210702	Догоод албан томилолт	900,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	235,000.00	327,820.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	235,000.00	00.00
210807	Газрын төлбөр	00.00	327,820.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,163,000.00	10,383,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,833,000.00	3,900,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,330,000.00	6,483,200.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	3,254,375.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	3,254,375.00
II ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		45,019,642.00	105,706,626.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	45,019,642.00	105,706,626.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,688,571.00	2,430,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	41,331,071.00	103,276,626.00

2.7 Аудит хийсэн ахмадын сангийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны к	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,995,200.00	15,075,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,995,200.00	15,075,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	00.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,995,200.00	15,075,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,995,200.00	15,075,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	26,108,613.96	58,037,703.00
12	Нэмэлт санхүүжилтийн орлого	26,108,613.96	58,037,703.00
12000	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас олох орлого	26,108,613.96	58,037,703.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	26,108,613.96	58,037,703.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	15,113,413.96
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	15,113,413.96	58,076,116.96

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Цагдаагийн газар нь тус аймгийн нутаг дэвсгэрт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журмыг сахиулах, хуулийг дээдлэн хүний эрхийг хамгаалж, амар тайван амьдралын баталгааг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлж Цагдаагийн ерөнхий газарт санхүүгийн тайлангаа нэгтгэдэг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын харьяа төрийн тусгай албаны байгууллага юм.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын дагуу цагдаагийн газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд “Монгол Улсын цагдаагийн байгууллагын ойрын болон дунд хугацааны тогтвортой хөгжлийг хангаж, үйл ажиллагааг боловсронгуй болгох, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох ажилд орчин үеийн менежментийн хэлбэр, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлж, үр дүнг дээшлүүлэх, иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, хүний нөөцийг бэлтгэх, мэдлэг, ур чадвар, чадавхыг сайжруулах, иргэдийн аюулгүй, амар амгалан амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино” стратеги төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 42 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж биелэлт 98,2 хувьтай, цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2023 онд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх шалгуур үзүүлэлтийг хангах чиглэлээр 2 зорилтын хүрээнд 14 ажил, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж биелэлт 99,2 хувьтай дүгнэгдсэн байна.

Төв аймгийн Цагдаагийн газар нь 2023 онд иргэн, аж ахуй нэгж байгууллагаас ирүүлсэн гэмт хэргийн шинжтэй 797 мэдээллээс гэмт хэргийн шинжгүй үндэслэлээр 345 гомдолд шалгалтын ажиллагааг явуулж шийдвэрлэн, 167 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 75 гомдол мэдээллийг гомдлын шатнаас эрүүгийн хэрэг үүсгэж, 370 зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэлд ажиллагаа явуулж 311 гомдол мэдээлэлд зөрчлийн хэрэг нээж шийдвэрлэн, зөрчлийн шинжгүй үндэслэлээр 14 гомдлыг шийдвэрлэж, хялбаршуулсан журмаар 125 гомдлыг шийдвэрлэж, 45 гомдлыг харьяаллын дагуу шилжүүлж, 12 гомдол мэдээллийн үлдэгдэлтэй байна.

Цагдаагийн газрын шинээр баригдах конторын 3 давхар барилгын 28.0 сая төгрөгийн зураг, төсвийн ажлыг “Амайзэ” ХХК-аар гүйцэтгүүлж, 2022 онд Аймгийн Засаг даргын Тамгын газраар санхүүжүүлж, Баян, Баянчандмань, Батсүмбэр, Бүрэн, Эрдэнэсант сумдад баригдах цагдаагийн хэсгийн төлөөлөгчийн байр /кобан/-ны 179.6 сая төгрөгийн зураг төсвийн ажлыг Алтан хөхийн очир ХХК-иар гүйцэтгүүлж, 2023 онд Барилга хот байгуулалтын ямаар зураг төсвийн хөрөнгийг санхүүжүүлж шийдвэрлүүлсэн байна.

Байгууллагын даргын 2023 оны жилийн эцсийн ажлын гүйцэтгэл, үр дүн, төсвийн шууд захирагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 94,88 хувьтай “А” үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

Төв аймгийн Цагдаагийн газар нь 2023 онд 1 хэлтэс, удирдлагын баг, 8 тасаг, 6 хэсэг гэсэн зохион байгуулалтын бүтцийн нэгжид офицер 131, ахлагч 88, энгийн 3, бүгд 222 орон тоо батлагдсанаас 199 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж, офицер 15, ахлагч 6, энгийн 2 орон тоо дутуу ажиллаж, хүний нөөцийн нөхөн хангалт 88 хувьтай байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Энэ онд иргэд, аж ахуй нэгж, байгууллагаас нийт 2435 гомдол мэдээлэл хүлээн авч, 2395 буюу 98,3 хувийг шийдвэрлэсэн, иргэн, аж ахуйн нэгжид 1,460,000.0 мянган төгрөгийн хохирол учирснаас 1,404,300.0 мянган төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, 96,1 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газраас зохион явуулсан “Устгал” нэгдсэн арга хэмжээний хүрээнд аймгийн Засаг даргын А/137 захирамжийн дагуу 8,500.0

мянган төгрөгийг шийдвэрлүүлж мансууруулах, сэтгэцэд нөлөөт үйлчилгээ үзүүлдэг хогийн, ургамлын тархац тогтоогдсон 6 сумдын нутаг дэвсгэрийн нийт 810 га талбайд устгал хийж ажилласан байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Цагдаагийн ерөнхий газрын Экологийн цагдаагийн албанаас Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, байгаль дэлхийгээ хамгаалах зорилгоор “Байгалиа хамгаалъя”, “Хүн бүр байгаль хамгаалагч”, “Эко-2023”, “Тэрбум мод”, “Нөхөн сэргээлт-2023” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж, уул уурхайн ашиглалтын улмаас эвдэгдэж орхигдсон Заамар сумын нутаг дэвсгэрийн 171 га газарт техникийн нөхөн сэргээлт, 189 га газарт биологийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгүүлсэн байна.

Шүүхээс торгуулийн биелэлтийг албадан гүйцэтгүүлэхээр 26 иргэнд холбогдох захирамжийг гаргуулан 8,750.0 мянган төгрөгийг нөхөн төлүүлсэн байна.

Төв аймгийн Цагдаагийн газар нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Цагдаагийн албаны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд буюу хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн өөрчлөлттэй холбоотой өөрчлөлтийг нэмж тусган мөрдөж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэхэд, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Цагдаагийн газар нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Цагдаагийн ерөнхий газрын 2013 оны 12 дугаар сарын 10-ны А/188 дугаар тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа ба тус бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна. Хууль тогтоомж, журмын өөрчлөлтийг тухай бүр хийж, шинэчлэлтийн хавсралтыг газрын даргын тушаалаар батлуулсан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Цагдаагийн газар нь 2023 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэж, 2024 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 47/01-395 тоотой Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 179,002.0 мянган төгрөгөөр буюу 12,9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	15,113.4	58,076.1	42,962.7
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Авлага	0.0	2,000.0	2,000.0
Бараа материал	281,697.8	362,124.0	80,426.2
Үндсэн хөрөнгө	1,096,327.0	1,149,960.1	53,633.1
Нийт хөрөнгө	1,393,138.2	1,572,160.2	179,022.0
Өр төлбөр	0.0	2,000.0	2,000.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,393,138.2	1,570,160.2	177,022.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,393,138.2	1,572,160.2	179,022.0

Дээрх хүснэгтээс харахад: Мөнгөн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 15,113.4 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 58,076.1 мянган төгрөг болж, 42,962.7 мянган төгрөгөөр өссөн нь ахмадын сангийн харилцах дансны үлдэгдэл өссөнтэй холбоотой байна.

Тайлант онд бараа материал дансны эхний үлдэгдэл 281,697.8 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 293,538.4 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, ЦЕГ болон харьяа цагдаагийн нэгж газруудаас 64,282.0 мянган төгрөгийн 33 ширхэг энгэрийн камер, 1050 ширхэг хэвлэмэл маягтууд, эрэлч нохойн төлөөлөгчийн 5 ширхэг хувцас хэрэгсэл, 2020 ширхэг тусгай хэрэгслүүд, Аймгийн Засаг даргын Тамгын газраас 8,700.0 мянган төгрөгийн 198 ширхэг мөрний гэрэл, 6700 ширхэг шийтгэлийн хуудас, шатахууны урамшуулалд 4,691.0 мянган төгрөгийн талон, төлийн орлогоор 2,562.0 мянган төгрөг, малын нас дэвшилтээр 12,697.1 мянган төгрөгийн мал амьтад, нийт 109,699.1 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй орлогод авсан байна.

Бараа материалын зарцуулалтыг тооцож бүртгэлд тусгахдаа эхэлж авснаа эхэлж зарлагдах аргыг хэрэглэдэг.

Алба хаагчдын албан хэрэгцээнд зориулж 294,708.3 мянган төгрөгийн материал зарцуулж, 18,625.8 мянган төгрөгийн бараа материалыг акталж, малын нас дэвшилт хийхээр 9,013.3 мянган төгрөгийн туслах аж ахуйн малыг хасалт хийж, цагдаа олон нийтийн сургалтын төвд 464.0 мянган төгрөгийн бараа материалыг хоорондын тооцоогоор шилжүүлж, нийт 322,811.3 мянган төгрөгийн материал зарлагдаж, жилийн эцсийн байдлаар 362,124.0 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй болж, өмнөх оноос 80,426.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 1,096,327.0 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 1,149,960.1 мянган төгрөг болж, 53,633.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Энэ нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 38,450.9 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, ЦЕГ-аас 5 ширхэг суурин компьютер, 2 ширхэг хэвлэгч, 2 ширхэг таблет, 4 ширхэг гар утас, нийт 20,168.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, аймаг, орон нутгаас хөлтэй 65 инчийн дэлгэц 4,700.0 мянган төгрөгийн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас 5,000.0 мянган

төгрөгийн гэр, Номтын ахмадуудын нэгдэл ТББ-аас хандив тусламжаар 26 сумын цагдаагийн хэсгийн төлөөлөгчийн байр /кобан/-д 52 ширхэг камер, 3 ширхэг хүлээлгийн сандал, 2 ширхэг архивын нягтаршуулсан шүүгээ, 1 ширхэг хурлын болон ажлын ширээ, Азийн хөгжлийн сангаас Заамар сумын цагдаагийн хэлтэст 2 ширхэг хяналтын камер, 1 иж бүрдэл компьютер, бусад тоног төхөөрөмж хандивлаж, нийт 59,675.2 мянган төгрөгийн хөрөнгийг хандиваар болон шилжүүлэн орлогод авч 226,159.7 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж орлогоор тайлагнасан байна.

Тайлант онд 351,855.5 мянган төгрөгийн хөрөнгө акталж, 252,591.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал гарсан байна.

Тус байгууллага авлага, өр төлбөр зэрэг тооцооны дансдад эхний үлдэгдэлгүй байсан, эцсийн үлдэгдэл 2,000.0 мянган төгрөг болж өссөн байна.

Энэ нь нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн ГХУСА33-өөс “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 46 дугаар зүйлийн дагуу гэмт хэргийн талаар мэдээлэл өгсөн нь батлагдсан иргэнд олгох төлбөртэй мэдээллийн 2,000.0 мянган төгрөгийн төлбөрийн үлдэгдлийг татан төвлөрүүлсэн тул авлага, өглөгөөр тайлагнасан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,393,138.2 мянган төгрөг болж 177,022.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд 5,958,348.7 мянган төгрөгийн зардлыг улсын төсвөөс 5,958,330.7 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 18,000.0 мянган төгрөг, нийт 5,958,348.7 мянган төгрөгөөр санхүүжүүлэх эх үүсвэрийг тооцон төлөвлөж Цагдаагийн ерөнхий газарт хүргүүлсэн байна. Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 776,358.0 мянган төгрөгөөр бууруулж, 2023 оны урсгал зардлын төсвийг 5,181,990.7 мянган төгрөгөөр баталж, улсын төсвөөс 5,166,384.7 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 15,606.0 мянган төгрөг, нийт 5,958,348.7 мянган төгрөгөөр санхүүжүүлэх эх үүсвэрийг тооцож ирүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төв аймгийн Цагдаагийн газрын 2023 оны батлагдсан төсөв 5,181,990.7 мянган төгрөгийг 1,461,969.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 6,643,960.6 мянган төгрөгөөр тодотгол хийгдсэн байна.

Энэ нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил нэмэгдсэн мөн урсгал шилжүүлгийн зардлын төсөв нэмэгдсэнтэй холбоотой байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 4 арга хэмжээг хэрэгжүүлэх 6,643,960.6 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр батлагдсаны дагуу гүйцэтгэлээр санхүүжилтийг 100 хувь олгож, оны эцэст улсын төсвийн санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдэл 3,027.9 мянган төгрөг, давсан орлогын 3,971.2 мянган төгрөг, нийт 6,999.1 мянган төгрөгийг төсөвт татан төвлөрүүлсэн байна. Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 6,640,932.7 мянган төгрөг байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 15,606.0 мянган төгрөг, гүйцэтгэлээр 19,577.2 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, давсан орлого 3,971.2 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70704- Цагдаа 80101- Үндсэн үйл ажиллагааны зардал	5,728,131.9	5,725,194.1	2,937.8	99.95%
2	70704- Цагдаа 80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал дэмжлэгийн зардал	779,595.4	779,505.3	90.1	99.99%
3	70704- Цагдаа 82315-Байцаан шийтгэх ажиллагаа	6,600.0	6,600.0	0	100%
4	70711- Шүүгч болон гэрч, хохирогчийг хамгаалах 80101- Үндсэн үйл ажиллагааны зардал	129,633.3	129,633.3	0	100%
	Дүн	6,643,960.6	6,640,932.7	3,027.9	99.95%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага нь нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагч, ЦЕГ-аас орон нутгийн нөхөн сонгуулийн хамгаалалтын зардалд 2,430.0 мянган төгрөг, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогод аймгийн ГХУСАЗСЗ-өөс 33,500.0 мянган төгрөг, аймгийн ЗД-аас 100 жилийн ойн баяр наадмын хамгаалалтын зардалд 48,508.9 төгрөг, ЦЕГ-аас орон нутгийн нөхөн сонгуулийн хамгаалалтын зардалд 2,430.0 мянган төгрөг, тендерийн жишиг бичиг баримт худалдан авахад 70.0 мянган төгрөг, бусад 32.3 мянган төгрөг, аймгийн Засаг даргын Тамгын газраас нэгдсэн арга хэмжээний зардалд 500.0 мянган төгрөг, Сангийн сайдын тушаалаар давсан орлогын 11,164.4 мянган төгрөг, галт зэвсэг эзэмшигчдэд төлбөртэй сургалтын 8,700.0 мянган төгрөг, Практикал даатгал ХХК-аас автомашины даатгалын төлбөрт 801.0 мянган төгрөг, нийт 105,706.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, холбогдох шийдвэрийн дагуу 102,452.2 мянган төгрөгийг зарцуулж, 3,254.4 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансны орлого, зардлын зарцуулалтыг зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.3.2 Ахмадын сан

Ахмадын сангийн дансны оны эхний үлдэгдэл 15,113.4 мянган төгрөг, Цагдаагийн газрын даргын тушаалаар Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д “Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах...” гэж заасныг үндэслэн 58,037.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, Ахмад настны тухай хууль, журмын дагуу 11 ахмадуудад буцалтгүй тусламжид 1,100.0 мянган төгрөг, ахмадын зөвлөлийн даргын урамшуулалд 3,000.0 мянган төгрөг, ахмадын баяраар 103 ахмадад хүндэтгэл үзүүлэхэд 10,975.0 мянган төгрөг, нийт 15,075.0 мянган төгрөг зарцуулж, мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 58,076.1 мянган төгрөг байна.

Ахмадын сангийн орлого, зардлын зарцуулалтыг зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.7-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт хоёр хөтөлбөрийн дөрвөн арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт / мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70704- Цагдаа	2023.01.01-2023.12.31	Цагдаагийн үйл ажиллагаа	Цагдаа хөтөлбөр 99.9 %	6,514,327.3	6,511,299.4
2	70711- Шүүгч болон гэрч, хохирогчийг хамгаалах	2023.01.01-2023.12.31	Шүүгч болон гэрч, хохирогчийг хамгаалах	Шүүгч болон гэрч, хохирогчийг хамгаалах хөтөлбөр 100%	129,633.3	129,633.3

Цагдаа /70704/ хөтөлбөрийг 99.9 хувиар, Шүүгч болон гэрч, хохирогчийг хамгаалах /70711/ хөтөлбөрийг 100 хувиар хэрэгжүүлж ажилласан байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Цагдаагийн газрын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 01 дүгээр сард батлуулан, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолын дагуу тээвэр шатахууны 192,800.0 мянган төгрөгийн зардлыг 3 багц болгон Цагдаагийн газрын даргын 2023 оны А/20 дугаар тушаалаар үнэлгээний хорооны ажлын хэсгийг томилж, нээлттэй тендер шалгаруулалтыг цахимаар зохион байгуулж, Магнай трейд ХХК нь тендерийн баримт бичигт тавигдсан шаардлагын дагуу шалгарсан тул гэрээ байгуулж, үр дүнг Засгийн газрын худалдан авах ажиллагааны tender.gov.mn системд нийтэлсэн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, худалдан авах ажиллагааны журмын дагуу тайлант оны жилийн батлагдсан төсөв нь үнийн доод хязгаарт хүрээгүй бичиг хэрэг, хог хаягдлын төлбөр хураамж, бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйл, эм, эмнэлгийн хэрэгсэл, хоол хүнс, урсгал засвар, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж, нормын хувцас зөөлөн эдлэл, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, хичээл, сургалт үйлдвэрлэлийн дадлагын зардлуудын зарцуулалтыг шууд худалдан авалт хийхээр Төв аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, хувь хүнийг өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, үнийн харьцуулсан судалгаа хийж, бараа материалын олдоц, чанар байдлыг харгалзан гэрээ байгуулж, хэрэгжүүлсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Цагдаагийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Баянжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Цагдаагийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 47/01-395 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Цагдаагийн газрын 2023 оны төсвийн төлөвлөгөөний нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Цагдаагийн газрын 2023 оны батлагдсан төсвийн нийт зарлага 6,612,132.1 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 99,182.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 74,386.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус байгууллага тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж хуулиар хориглосон зардлууд гараагүй, төсвийн хөрөнгийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулж Сангийн сайдын 134 дүгээр тушаалын дагуу төсөвт 2 удаа зохицуулалт хийж, хэмнэлтэй байгаа зардлаас түлш халаалт, гэрэл цахилгааны зардалд шилжүүлэн зарцуулж ажилласан

Төсөв дутагдсанаас шалтгаалан үүссэн цэвэр бохир усны 720.4 мянган төгрөг, тээвэр шатахууны зардлын 1,072.5 мянган төгрөг, хог хаягдлын хураамжийн 416.4 мянган төгрөг, тоног төхөөрөмжийн 3,558.2 мянган төгрөг, газрын төлбөр хураамжийн 327.8 мянган төгрөг, шуудан холбооны зардлын 1,270.2 мянган төгрөг, эмийн зардлын 379.0 мянган төгрөг, урсгал засварын зардлын 3,268.9 мянган төгрөг, спорт заалны 150.0 мянган төгрөгийг ер төлбөрийг давсан орлогоос барагдуулж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Цагдаагийн газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад Тендер шалгаруулсан худалдан авах ажиллагааны 17 мэдээлэл, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 25, зарлагын 69 мөнгөн гүйлгээг болон төсөв, өмч, хөрөнгө мөнгө зарцуулах шийдвэрийн 23 мэдээллийг хугацаандаа бүрэн байршуулж, байршуулбал зохих 171 мэдээллээс, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 1 мэдээлэл, хугацаандаа байршуулсан 168 мэдээлэл, хуулийн хэрэгжилт 99.7 хувьтай байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Цагдаагийн газрын эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Завсрын аудитын явцад асуудлын бүртгэлээр 3 зөвлөмж өгөгдсөн ба биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянаад, 1 зөвлөмжийг дараагийн аудитаар анхаарах асуудлаар тодорхойлж, 2 зөвлөмж нь үр дүнтэй хэрэгжсэн тул аудитын тайланд тусгаагүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	0	0.0	0	0.0	0
Албан шаардлага	0	0.0	0	0.0	0
Зөвлөмж	0	0.0	0	0.0	0
Нийт дүн	0	0.0	0	0.0	0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Цагдаагийн газрын дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудлаар төсвийн нэгдсэн системийн программ хангамжийн байнгын ажиллагаа, хөгжүүлэлт, төсвийн гүйцэтгэлд хяналт хийж, төсвийн төслийг боловсруулахад хэрхэн ашиглаж, үр дүн гаргаж байгаа байдлыг үзэхээр тодорхойлж байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар төсвийн гүйцэтгэлийн тайлан, нэмэлт санхүүжилтийн тайлан, ахмадын сангийн тайлангууд нь өмнөх үеийн тоон үзүүлэлтүүдтэй зэрэгцүүлэхүйц байх зарчмыг хангаж бэлтгээгүй 1 алдаа¹ илэрснийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу аудитын явцад залруулсан.

Аудитаар зөрчил² илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

